



ЧИНГЭЛТЭЙ ДУУРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Хурлын хороодыг хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтын 5.1.2 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2025 оны V хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Хурлын хороодыг хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Хурлын хороодын хуралдах хуваарь, хэлэлцэх асуудал бүхий удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Хурлын хороод хуралдахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын даргын 2025 оны 03 дугаар сарын 29-ний  
өдрийн 29 дугаар захирамжийн хавсралт

УДИРДАМЖ

Хурлын хороодыг хуралдуулах тухай

Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороод дараах хуваарийн дагуу хуралдах бөгөөд хэлэлцсэн асуудлаар санал, дүгнэлт гаргана.

Хоёр. Хурлын хороод хэлэлцсэн асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Хурлын Зөвлөлд танилцуулна.

Гурав. Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс, албад Хурлын хороодыг шаардлагатай мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, ажиллах нөхцөлөөр хангана.

Дөрөв. Хурлын хороод хуралдахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.

Тав. Хороодын ажиллах хуваарь, хэлэлцэх асуудал:

Д/д	Хурлын хороод	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хугацаа	Хамтран ажиллах хэлтэс, албад
1	2	3	4	5
1	Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо (Өргөтгөснөөр)	<ul style="list-style-type: none"><li>Орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай</li><li>Дүрэм шинэчлэн батлах тухай</li><li>Санал уламжлах тухай</li><li>Үндэсний бичгээр хаягжуулах тухай</li><li>Эрх шилжүүлэх тухай</li></ul>	2025 оны III/24-ний өдрийн 09 <sup>00</sup> цагт, Хурлын танхимд	Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газрын Төрийн захирагааны удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс
2	Ногоон хөгжил, газрын харилцааны хороо (Өргөтгөснөөр)	Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2025 оны III/24-ний өдрийн 13 <sup>00</sup> цагт, Хурлын танхимд	Дүүргийн Газар зохион байгуулалтын алба